



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 5/110

Хэрлэн сум

Ч.Баярцолмонг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Монгол Улсын сайд, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чимэдбатын Баярцолмонг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд 2023 оны 7 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилсугай.

2. Ч.Баярцолмонгийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын

дарга:

Б.Дарханбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ш.Эрдэнэжаргал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Э.Ариунтунгалаг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч

Д.Энхтуяа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч

3. Ч.Баярцолмонд аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын үндсэн цалинг тооцож, холбогдох бусад нэмэгдлүүдийг хууль, журамд заасны дагуу олгохыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ч.Баярцолмонд үүрэг болгосугай.

5.Ч.Баярцолмонд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

